



## ТЕНДЕРИЙН УРИЛГА (дахин зар)

Огноо: **2024 оны 07-р сарын 22**  
Зээлийн дугаар ба нэр: **EIB F183873: “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - 2”**  
Гэрээний дугаар ба нэр: **SHFP: ШАР ХАД ДЭД ТӨВИЙН ҮЕРИЙН ХАМГААЛАЛТЫН СУВГИЙН АЖИЛ**  
Тендер хүлээн авах эцсийн хугацаа: **2024 оны 08-р сарын 22-ны өдрийн 15:00 цаг /Улаанбаатарын цагаар/**

1. Монгол улсын Засгийн газар Европын Хөрөнгө Оруулалтын Банк (цаашид “ЕХОБ” гэх)-наас **“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-2”-ийг** хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурдсан гэрээний хүрээнд хийгдэх төлбөрт ашиглана. Тендерийн шалгаруулалт нь ЕХОБ-ны эрх бүхий орны харъяат тендерт оролцогчдод нээлттэй байна.
2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь (Цаашид “Захиалагч” гэх) эрх бүхий тендерт оролцогчдоос SHFP: Шархад дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн ажил (цаашид “ажил” гэх)-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Гэрээний дугаар, нэр	Ажлын тодорхойлолт
SHFP: Шархад дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн ажил	Үндсэн ажилд доорх ажлууд орно. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>- ҮХС-2-5 суваг 0.4928 км урт трапец хөндлөн огтлолтой, ҮХС-3 суваг 0.2365 км урт тэгш өнцөгт хөндлөн огтлолтой суваг, түшиц хана, төмөр бетон хоолойг ханган нийлүүлж угсрах;</li><li>- Автомашин болон явган хүний гарц 2 байрлалд</li></ul>

3. Энэхүү тендерийн шалгаруулалтыг ЕХОБ-тай зөвшилцсөний дагуу АХБ-ны дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар явуулна.
4. Зөвхөн доор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендерт оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно:
  - 4.1 Санхүүгийн чадавхийн одоогийн байдлыг харуулах зорилгоор **сүүлийн 3 жилийн (2021, 2022, 2023)** аудитын дүгнэлтээр баталгаажуулсан санхүүгийн тайланг илгээнэ. Тендерт оролцогчийн цэвэр хөрөнгийн доод хэмжээг нийт актив хөрөнгө

ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцно. Энэхүү зөрүү нь аль нэг хоёр жилд эерэг буюу ашигтай байвал зохино.

- 4.2 **Сүүлийн 3 жилд (2021, 2022, 2023 онуудад)** хэрэгжиж дууссан эсхүл хэрэгжиж байгаа гэрээт ажлын хүрээнд хүлээн авсан баталгаат төлбөрийн нийт дүнгээр тооцсон барилгын ажлын жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ нь **1.5 тэрбум** төгрөг байх;
- 4.3 САНХ-4 маягтад тусгагдсан санхүүгийн эх үүсвэрт тавигдах шаардлагыг хангахуйц түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, зээлийн шугам эсхүл бусад санхүүжилтийн эх үүсвэрийг (гэрээний урьдчилгаа төлбөр үүнд хамаарахгүй) олж авах эрхтэй, эсхүл авах боломжтой гэдгээ илтгэн мэдээлэх шаардлагатай. Шаардлага хангахуйц түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн доод хэмжээ **380.0 сая** төгрөг байх;
- 4.4 **Сүүлийн 3 жилд (2021, 2022, 2023 онуудад)** амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх, ингэхдээ тендерт оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь **900.0 сая** төгрөгөөс доошгүй байх;
- 4.5 Эрх бүхий байгууллагуудаас олгосон, хүчин төгөлдөр дараах тусгай зөвшөөрлүүд шаардлагатай. Үүнд:

**Барилга, хот байгуулалтын яамны** дараах тусгай зөвшөөрлүүд шаардлагатай.

- **БА-3.2** Усны барилга, байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил

Хэрэв Гүйцэтгэгч нь Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Дүрэм шинэчлэн батлах тухай 217 дугаар тушаалаас өмнөх ажлуудын төрлөөр хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл эзэмшиж буй бол Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Аргачлал батлах тухай 33 дугаар тушаалаар батлагдсан аргачлалаар дүйцүүлнэ. Тухайн тусгай зөвшөөрлийг гэрчилгээнд заасан хугацаанд хүчинтэй байхаар тооцно.

Гадаадын тендерт оролцогчдоос дээрх тусгай зөвшөөрлийг шаардахгүй болно. Гадаадын тендерт оролцогч нь дээр заасан, хүчинтэй тусгай зөвшөөрөлтэй дотоодын тендерт оролцогчтой (i) түншлэлийн гишүүн, эсвэл (ii) туслан гүйцэтгэгчийн хэлбэрээр нэгдэж болно.

5. Сонирхсон тендерт оролцогч нь [procurement@ub-subcenter.mn](mailto:procurement@ub-subcenter.mn). цахим хаягт хандан бичгээр хүсэлт гаргаж, **350,000.00 төгрөгтэй** тэнцэх эргэн үл төлөгдөх хураамжийг төлсөн баримтын хамт илгээснээр тендерийн баримт бичгийг цахим хэлбэрээр хүлээн авна. Төлбөрийг дараах дансанд шилжүүлнэ.

<b>For foreign transfers:</b> Account Name: Ministry of Finance of Mongolia Details of payment: 101900011857 Bank Account No: 101900011857 Bank Name: State Treasury Bank of Mongolia, Bank Address: Ulaanbaatar, Mongolia SWIFT Code: STBMMNUB Correspondent bank: Kookmin Bank SWIFT Code: CZNBKRSE Account No (USD): 7968USD019	<b>Дотоод шилжүүлэг:</b> Дансны нэр: УБГХХХОДХ төсөл урсгал Төсөл 2 Банкны хаяг: Төрийн сан, (MNT): 101900011856
---	--

6. Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.

Холбоо хаяг	барих	Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр Соёлын төв өргөө, 404 тоот өрөө Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Амарын гудамж-2, Улаанбаатар хот 14200 Монгол Улс
Утас		+976 7000-3099
Цахим шуудан		<a href="mailto:procurement@ub-subcenter.mn">procurement@ub-subcenter.mn</a>

#### 7. Тендерийг доорх хаягаар

- Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр  
Соёлын төв өргөө, 404 тоот өрөө Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Амарын гудамж-2, Улаанбаатар хот 14200 Монгол Улс  
Утас: +976 7000-3099
- тендер хүлээн авах эцсийн хугацаа болох **2024 оны 08 сарын 22-ны өдрийн 15:00 цагаас** /Улаанбаатарын цагаар/ өмнө,
- тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.

Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана. Тендерийг **2024 оны 08 сарын 22-ны өдрийн 15:05 цагт** тендерт оролцогчдын төлөөллийг (хэрэв тэд оролцохыг хүсвэл) байлцуулан нээнэ.